



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 29

Эрэнгэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19-р зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаал, "Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн өмчийн газрын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах явц" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгуулах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч үр дүнг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Л.Оюунгэрэл/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 3 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /О.Дашжамц/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**“Орон нутгийн өмчийн газрын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр
бараа, ажил, үйлчилгээ худалдан авах явц” нийцлийн аудит**

**Орон нутгийн өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр
бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 7.6
хувийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.**

**Орхон аймаг
2017 он**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 тоот тушаалаар батлагдсан Орхон аймаг дахь төрийн аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн өмчийн газрын 2016 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах явц түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгон, үнэлгээний хороог хууль журмын дагуу байгуулсан эсэх
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх
- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу тайлагнасан эсэх

3. Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг сумын Засаг Даргын Тамгын Газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, 2016 оны аймгийн худалдан авалтын төлөвлөлт, тендер шалгаруулалт, түүнд тавьсан хяналт, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2013 оны 68-р тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 264, 290 тушаал
- Сангийн сайдын 2013 оны 84-р тушаал
- Сангийн сайдын 2015 оны 330-р тушаал
- Бусад холбогдох хууль, журмууд

6. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитын явцыг хянан удирдах ажилтан: Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүллээ.

Аудит хийсэн аудиторууд: Д.Цогбадрах, О.Дашжамц, Б.Буян-Ундрах, Б.Бямбатогтох нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

7. Аудитын тайлан, баталгаажуулалт:

Аудитыг 2017 оны 05 дугаар сарын 05-нд эхэлж, талбарын ажлыг 06 дугаар сарын 20-нд дуусгаж, аудитын тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2017.12.27-д холбогдох байгууллагуудад хүргүүлэн саналыг авч, Тэргүүлэх аудиторроор баталгаажуулан 2017 оны 12 сарын 28-ны дотор аймгийн ИТХ-д хүргүүллээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт судалгаа, холбогдох байгууллагын саналыг тусгалаа.

Ерөнхий мэдээлэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2144.4 сая төгрөгийн 5 худалдан авах ажиллагаа төлөвлөж, 1995.1 сая төгрөгөөр 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 22490.5 сая төгрөгийн 198 худалдан авах ажиллагаа төлөвлөж, 21835.4 сая төгрөгийн 197 ТАХ-нд, ОНХС-ийн хөрөнгөөр 4872.9 сая төгрөгийн 137 худалдан авах ажиллагаа төлөвлөж, 4207.1 сая төгрөгийн 136 ТАХ-нд, нийтдээ Орхон аймгийн хэмжээнд 29507.9 сая төгрөгийн 340 худалдан авах ажиллагаа төлөвлөн 28037.7 сая төгрөгийн 338 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулжээ.

Эдгээр ажлуудаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 54, харьцуулалтын аргаар 179, олон нийтийн оролцоот худалдан авалт 30, зөвлөх сонгох бага үнийн аргаар 5, зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргаар 1, шууд худалдан авалтын аргаар 69 худалдан авалтууд тус тус хийгдсэн байна.

Дээрх ажлуудыг зориулалтаар ангилбал:

- Авто зам засвар, өргөтгөл, шинэчлэл, явган хүний замын 40 ажил,
- Гэрэлтүүлэг, цахилгааны 33 ажил,
- Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 30 ажил
- Барилга засварын 111 ажил,
- Шинээр барих барилга угсралтын 4 ажил,
- Ногоон байгууламж, хөдөө аж ахуйн 10 ажил,
- Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах 93 ажил,
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 6 ажил,
- Зөвлөх болон зөвлөхөөс бусад үйлчилгээ 6 ажил,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төслийн 5 ажил байна.

Аудитад дээрх хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг 100% хамрууллаа.

Бүлэг.1. Худалдан авах ажиллагааны аргыг хуулийн дагуу сонгон, батлагдсан зориулалтын дагуу зохион байгуулж, үнэлгээний хороог хууль журмын дагуу байгуулсан байна.

1.1 Худалдан авах ажиллагааны аргыг хуульд нийцүүлэн сонгон ажилласан байна.

2016 онд Орон нутгийн өмчийн газрын зохион байгуулсан 202 худалдан авалтын 44 нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 139 нь харьцуулалтын аргаар, 3 нь зөвлөх сонгох аргаар, 16 нь шууд гэрээ байгуулан ажилласан байна. ОНХС-ын хөрөнгөөр Баян-Өндөр, Жаргалант сумдад зохион байгуулагдсан 136 худалдан авалтын 10 нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 70 нь харьцуулалтын аргаар, 3 нь зөвлөх сонгох аргаар, 53 нь шууд гэрээ байгуулан ажилласан байна. Эдгээр төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааны аргыг сонгохдоо ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.2 Аймаг, сумдын хэмжээнд Үнэлгээний хороодод орж ажилласан ажилтнууд нь бүгд ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу худалдан авах ажиллагаанд мэргэшсэн байна.

Аймаг, сумдын хэмжээнд Үнэлгээний хороодод орж ажилласан ажилтнууд нь бүгд ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.6-д “Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэсэн заалтын дагуу худалдан авах ажиллагаанд мэргэшсэн, АЗ сертификаттай байна. Үнэлгээний хороодод Төрийн бус байгууллага, иргэний төлөөллийн АЗ сертификаттай мэргэшсэн ажилтанг 100% хамруулсан байна.

1.3. Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөл, арга хэмжээний зориулалтын дагуу зохион байгуулжээ.

2016 онд улс, орон нутгийн төсвөөр болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 338 худалдан авах ажиллагааг ИТХ-аас батлагдсан төсөл, арга хэмжээний зориулалтын дагуу зохион байгуулжээ. Эдгээр нь:

- 3,300.6 сая төгрөгөөр авто зам засвар, өргөтгөл, шинэчлэл, явган хүний замын 40 ажил,
- 1,907.2 сая төгрөгөөр гэрэлтүүлэг, цахилгааны 33 ажил,
- 3,649.8 сая төгрөгөөр инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 30 ажил,
- 5,880.4 сая төгрөгөөр барилга засварын 111 ажил,

- 4,114.7 сая төгрөгөөр шинээр хийх барилга угсралтын 4 ажил,
- 226.8 сая төгрөгөөр ногоон байгууламж, хөдөө аж ахуйн 10 ажил,
- 6,762.5 сая төгрөгөөр тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах 93 ажил,
- 66.7 сая төгрөгөөр шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 6 ажил,
- 90.8 сая төгрөгөөр зөвлөх болон зөвлөхөөс бусад үйлчилгээ 6 ажил,
- 1,995.1 сая төгрөгөөр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төслийн 5 ажил байна.

Бүлэг.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 92.4 хувийг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

2.1. Зарим тендер шалгаруулалтад худалдан авах ажиллагааны дараах хууль журмуудыг зөрчсөн байна.

Орон нутгийн өмчийн газарт улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар харьцуулалтын аргаар нийт 139 худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн урилгыг хүргүүлсэн, хүлээн авсан талаарх баримт нотлогдохгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 33.2.1-т “техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх”, 49.1-т “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2-т “Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ”, 49.2.4-т “захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Харьцуулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулахдаа захиалагч тендерт шаардсан шаардлага, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.2-т “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэж заасан шаардлагыг хангахгүй гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Үүнд:

- 25.0 сая төгрөгөөр “Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын хойд бүс дахь газарт автомашин нийлүүлэх” тендерт 2010 оноос хойш үйлдвэрлэгдсэн 3.0 дээш хөдөлгүүртэй автомашиныг шаардсан боловч 2007 онд үйлдвэрлэгдсэн автомашиныг худалдан авсан,

- 20.8 сая төгрөгөөр Орхон цогцолбор сургуулийн спорт заалны засварын ажлыг гүйцэтгэсэн байгууллага нь борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна гэсэн шаардлагыг хангаж чадаагүй,
- 50.0 сая төгрөгөөр 5-р хорооллын 6, 7, 8, 10, 13, 41-р байрнуудын хаалгыг соронзон цоожтой хаалгаар солих ажлыг гүйцэтгэсэн байгууллага нь соронзон кодтой хаалга хийж байсан туршлагагүй байна.

Нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар явагдсан дараах тендерүүдэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16-р зүйлийг хангахгүй, тендерийн баримт бичигт шаардсан баримт бүрдэл дутуу ирүүлсэн хэдий ч дараах байгууллагууд шалгарсан зөрчил илэрлээ.

- 49.9 сая төгрөгөөр Зэст багийн амралт чөлөөт цагийн талбайн ажлыг гүйцэтгэсэн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрээ байхгүй,
- 85.3 сая төгрөгөөр "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" цогцолборын барилгын тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгээс буюу 87.0 саяас багагүй байх гэж заасан. Тендерт шалгарсан байгууллага нь 2014 онд 45.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 2015 оны жилийн эцсийн тайлангаа тендерт ирүүлээгүй байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 27.1-т "Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ" 27.1.1-т "энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага", 27.3-т "Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ", 29.1-т "Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн байгууллагын санхүүгийн тайлан болон татварын байгууллагын тодорхойлолт дахь борлуулалтын орлогын дүн зөрүүтэй байгаад дүн шинжилгээ хийж, тодруулга авах шаардлагатай байна.

2.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нийт худалдан авах ажиллагааны 6.2%-д өрсөлдөөнийг хугацаагаар болон Үнэлгээний хорооны дүгнэлтээр хязгаарласан байна.

Аймгийн хөрөнгө оруулалт болон Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад Үнэлгээний хорооны олонхийн гаргасан шийдвэрээр ТБОНӨХБАҮХАТХуулийн 28.7.4-т “хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ” гэсэн заалтыг зөрчин “Хамгийн сайн” үнэлэгдсэн буюу тендерийн шаардлага хангасан хамгийн бага үнийн санал ирүүлсэн тендерийг шалгаруулаагүй дараах худалдан авах ажиллагаанууд байна.

д/д	Ажлын нэр	Хуулийн дагуу шалгарах ёстой байгууллага	Үнийн санал /мян.төг/	Шалгарсан байгууллага	Гэрээний дүн /мян.төг/
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн					
1	Их залуу багийн ИШС-ний өргөтгөл	Гом илч ХХК	75,853.7	Харьцуулалт амжилтгүй болж улмаар “Нэгдэл трейд” ХХК-тай шууд гэрээ байгуулсан	75,000.0
2	"Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-д автовишк автомашин худалдан авах	Агротрейд импекс ХХК	68,800.0	Мөнхмацу ХХК	116,900.0
Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн					
3	6 байршилд ус түгээх байранд ухаалга төхөөрөмж, цахилгаан халаагч суурилуулах	Эйч Ти Эл ХХК	72,127.0	Алтайн ХХК	84,600.0
Нийт			216,780.7		276,500.0

“Их залуу багийн ИШС-ний өргөтгөл” ажилд 75,853.7 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Гом илч ХХК”-ыг төсөвт өртөг нь 75,000.0 мянган төгрөг хэдий ч хяналтын төсөв болон 84,300.0 мянган төгрөгийн 90%-аас бага үнийн санал ирүүлсэн, чанаргүй ажил хийгдэнэ гэсэн үндэслэлээр хассан, улмаар шууд гэрээг түүнээс бага буюу 75,000.0 мянган төгрөгөөр байгуулсан.

"Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-д автовишк автомашин худалдан авах ажилд 68,800.0 мянган төгрөгийн санал ирүүлсэн “Агротрейд импекс” ХХК нь шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн байтал шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй “Мөнхмацу” ХХК-ийг шалгаруулж 116,900.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

6 байршилд ус түгээх байранд ухаалга төхөөрөмж, цахилгаан халаагч суурилуулах ажилд Эйч Ти Эл ХХК-ийн ирүүлсэн 72,127.0 мянган төгрөгийн үнийн саналыг хэтэрхий бага,

ажил чанаргүй болох магадлалтай гэсэн үндэслэлээр хасаж 84,600 мянган төгрөгөөр гүйцэтгэгчийг шалгаруулсан.

“ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитаар Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр олон нийтийн оролцоотой хийгдсэн 179,316.6 мянган төгрөгийн орц засварын 13 ажилд гэмт хэргийн шинж чанартай зөрчлүүд илэрсэн тул дараагийн шатанд шилжүүлсэн болно.

Орон нутгийн өмчийн газарт шалгаруулалт явагдсан ТБОНӨХБАҮХАТХуулийн 24.1-т “Захиалагч тендер оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно”, 24.2-т “Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцож тогтооно”, 24.3-т “Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно” гэсэн заалтуудыг зөрчин нээлттэй тендерийг 30-аас бага хоногт зарлаж, тендер оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоогүй, өрсөлдөөнийг хязгаарласан дараах ХАА-нууд байна. Эдгээр нь:

- 574,061.6 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн “Баян-Өндөрийн гудамжийг Хантайн гудамжтай холбох автозам /Б хэсэг 0.828 км/” ажлын тендерийг 17 хоногийн хугацаатай,
- 246,905.8 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн “ЭУДТС” ОНӨХК-с Баян худалдааны төвийн уулзвар хүртэлхи авто замын засвар, шинэчлэлтийн ажлын тендерийг 17 хоногийн хугацаатай,
- 189,961.3 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн Баянцагаан багийн ПДУ-н хэсгийн айл өрхийг төвлөрсөн ИШС-нд холбох ажлын тендерийг 7 хоногийн хугацаатай,
- 89,990.4 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн “Эрдэнэ багийн авто замын гэрэлтүүлэг” ажлын тендерийг 17 хоногийн хугацаатай,
- 918,500.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн “Эрдэнэт амьдрал” ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах, ИШС, зам талбайн тохижилтын ажлын тендерийг 23 хоногийн хугацаанд зарласан зөрчилтэй байна.

2.3 2019.4 сая төгрөгийн 5 худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй, 299.0 сая төгрөгийн 2 нээлттэй тендер шалгаруулалтын гэрээг хуульд заасан хугацаанд байгуулаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТХуулийн 29.2-т “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэж заасан заалтыг зөрчин гэрээ байгуулах мэдэгдэл олгосноос 5-аас доош хоногийн дотор гэрээ байгуулсан дараах худалдан авах ажиллагаанууд байна. Эдгээр нь:

- 99.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Орон гэргүй иргэдэд гэр худалдан авах” ажлын гэрээ байгуулах эрхийг 2016.05.09-д олгож, тухайн өдөртөө гэрээ байгуулсан,
- 200.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Орон гэргүй иргэдэд гэр худалдан авах” ажлын гэрээ байгуулах эрхийг 2016.03.16-д олгож, 2016.03.17-д гэрээ байгуулсан.

Хугацаа давхардуулан өмнөх ажлаа дуусгаагүй давхар ажил авч гүйцэтгэсэн дараах байгууллагууд байна.

- Жавхлан харгуй ХХК – 5 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан
- ДБЧЭ ХХК – 3 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан
- Хөх тавилан ХХК – 2 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан
- Очиртон ХХК -2 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан
- Өлзий хутагтын наран ХХК – 2 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан
- Роял Алтай констракшн ХХК – 2 ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

Мөн өмнөх бүлэгт өгүүлсэн нээлттэй тендерийг 30-аас бага хоногт зарлаж ТБОНӨХБАҮХАТХуулийн 24.3 дахь заалтыг зөрчсөн 2019.4 сая төгрөгийн 5 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Дээрх зөрчлүүдийн дагуу холбогдох байгууллагуудад зөвлөмж, албан шаардлага хүргүүлээ.

Бүлэг. 3 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу гүйцэд тайлагнасан байна.

3.1. Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим хуудсаар явцыг тайлагнасан байна.

ТБОНӨХБАҮХАТХуулийн 52.1.12-т “худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох” гэж заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем mers.gov.mn цахим хуудсанд худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулж ажилласан байна. Мөн Орхон аймгийн ЗДТГ-ын www.erdenet.mn цахим хуудсанд ажлын нэр, шалгарсан байгууллага, төсөвт өртөг, хугацаа

зэргийг худалдан авах ажиллагааны тайланд нэгтгэн улирал тутамд мэдээлж ажилласан байна.

3.2. Шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг байршуулахдаа хугацаа хоцроосон байна.

2016 оны худалдан авалт, тендерийн мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 3.1-т “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна” 3.1.1-т “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 3.2-т “Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна” 3.2.4-т “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа” гэж заасан заалтын дагуу Шилэн дансны “shilendans.gov.mn” цахим хуудсанд худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулахдаа 2016, 2017 оны төлөвлөгөөг хугацаа хоцорч байршуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Орон нутгийн өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 7.6 хувийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны аргыг хуулийн дагуу сонгон, батлагдсан зориулалтын дагуу зохион байгуулж, үнэлгээний хороог хууль журмын дагуу байгуулсан байна.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 92.4 хувийг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу гүйцэд тайлагнасан байна.

ЗӨВЛӨМЖ**Аймгийн ЗДТГ-т:**

- Шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХуулийн 34.2 дэх заалтын дагуу шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах.

Орон нутгийн өмчийн газарт:

- Харьцуулалтын аргаар зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанд үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн урилгыг хүргэсэн, хүлээн авсан талаарх нотлох баримтыг үйлдэж, тендер сонгон шалгаруулалтын баримт бичигт хавсаргаж байх,
- Санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт, нийгмийн даатгалын тайлан зэргийг хооронд нь харьцуулж, дүн шинжилгээ хийн, тодруулга авч байх,
- Захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлагыг хангаж чадахгүй, тендерт шаардсан баримт материалыг дутуу ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг тендерт гүйцэтгэгчээр шалгаруулахгүй байх,
- Шилэн дансны мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулж байх.

МЭДЭГДЭЛ:

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг мэдэгдье.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

О.ДАШЖАМЦ
Д.ЦОГБАДРАХ
Б.БУЯН-УНДРАХ
Б.БЯМБАТОГТОХ

Хавсралт № 1

Нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Д/Д	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч байгууллага	Хариуцагч		Зөрчил	Алдаа
			Албан тушаал	Нэр		
1	Нээлттэй тендер шалгаруулалтыг 30-аас бага хоногт зарлаж явуулсан.	Орон нутгийн өмчийн газар	Дарга	Л.Оюунгэрэл		2019.4
Нийт дүн						2019.4

Албан шаардлагыг хариуцагч байгууллагуудад эх хувиар хүргүүлсэн, зөрчлийг дэлгэрэнгүй тайланд тусгасан.